

# УГСААТНЫ НИЙТЛЭГИЙН НИЙГМИЙН СТАТУС

*И.САРУУЛ*

*Түүхийн ухааны доктор (PhD)*

Угсаатны бүлгүүдийн оршихуй хийгээд нийгэмд гүйцэтгэх үүрэг нь угсаатны нийтлэгийн өөртөө тохирсон нийгмийн тодорхой орчинг бүрдүүлж байдаг зүй тогтолтой. Тэрхүү угсаатны өвөрмөц орчинд бодгалиуд (хүмүүс) амьдарч, аж төрж, ухамсрын төлөвшил бүрддэг. Үүний зэрэгцээ бодгалиуд нь тухайн угсаатны нийгмийн бичил (дотоод) орчноос өргөн хүрээ бүхий нийгмийн орчинд үйл ажиллагаа явуулах шаардлага гарч ирнэ. Тиймээс угсаатны нийтлэг ба түүний гишүүдийн нийгэмд эзлэх байр суурь, гүйцэтгэх үүрэг зэрэг нь нийгмийнхээ статусаас хамаардаг. Угсаатны нийгмийн статус гэдэг бол угсаатны нийтлэг бусад угсаатны бүлгүүд, ерөнхийлөн харьяалах засаг ба түүний институтуудтай харилцах, хамтран ажиллах нөхцлийг бүрдүүлэх ба нийгмийн бүтцэд угсаатны нийгмийн эзлэх байр суурийг тодорхойлж байдаг нийгмийн чанартай шинж чанаруудын цогц юм. Тиймээс угсаатан судлал, улс төр судлал, социологи зэрэг шинжлэх ухаанууд угсаатны нийгмийн статуст угсаатны нийтлэг дэх бодгалийн статусын ялгаанд ихээхэн анхаардаг.

Нийгэмд угсаатны нийтлэгийн эзлэх байр суурийг тодорхойдог хэдэн статус байдаг. Үүнд: *нийгэм – эдийн засаг, нийгэм – соёл, нийгэм – улс төр, хүн ам зүй, экологи, эрх зүй, нийгэм – сэтгэл зүй* гэх мэт.

*Нийгэм – эдийн засгийн статус* нь угсаатны нийтлэг, түүний гишүүн бүхэнд нийгмийн материаллаг баялгаас хүртэж байгаа хувь хэмжээгээр тодорхойлогддог. Угсаатны бодгаль гишүүний бодит орлого (жил, сар, улирлаар), цалингийн дундаж үзүүлэлт (энэ нь бодит орлоготой нь тэр болгон тохирч байдаггүй), ажилгүйдэл ба ажлын байрны хангамж төдийгүй тэр тусмаа мэрэгжлийн ажил, ахуйн ба орон сууцны хангамж, тэрчлэн унаа тээврийн хэрэглээ, эмнэлэг, үйлчилгээ зэрэг бодит байдал хамаарна. Эдгээр үзүүлэлтүүд нь бусад угсаатнуудын мөн ийм төрлийн үзүүлэлттэй тохирч байгаа эсэх нь угсаатны нийтлэгийн нийгэм-эдийн засгийн эрх тэгш байдлыг тодорхойлдог. Энэ нь амьдралын түвшин ба чанарыг тодорхойлогч үзүүлэлт юм.

*Нийгэм - соёлын статус* нь угсаатны нийтлэгийн оршин суугаа улс, дэлхийн соёлын санд оюуны ямар үнэт зүйлийг бүтээж оруулсан хувь нэмэр, гүйцэтгэж байгаа үүрэг, түүнээс хүртэж байгаа хэмжээгээр тодорхойлогддог. Энэхүү статусыг бүрдүүлэгч нь үндэсний хэл, түүний нийгэмд эзлэх байр суурь (ноёрхсон, эрх тэгш хэрэглэгддэг, эрх тэгш бус хэрэглэгддэг, гадуурхагдсан), аман зохиол (фольклор), уран зохиол, урлаг, шашин шүтлэг, сүм хийд, шинжлэх ухааны хөгжил, театр гэх мэт бөгөөд тэдэнд тохирох байгууллагатай эсэхээр нь шалгуур болгодог. Эдгээрээс хамгийн чухал нь үндэсний хэл бөгөөд, угсаажилтын үндсэн шинж болно.

*Нийгэм – улс төрийн статусын* үндсэн шалгуур нь төр улсын институттай эсэхээр нь тодорхойлдог. Бие даасан улс, эсвэл автономит засаглалыг тогтоосон эсэхээр. Төр улсын байгуулалгүй угсаатны нийтлэгүүд нь олон улсын статусгүй байдаг. Тиймээс угсаатны нийтлэгүүд ямагт бие даан тусгаар тогтнохын төлөө тэмцдэг. Тухайлбал, ОХУ-ын Чечень тусгаар тогтносон улс байгуулахаар тэмцээд зогсохгүй 1998 онд НҮБ - д гишүүнээр элсүүлэх хүсэлтээ гардуулсан. Угсаатны статус нь мөн засаг захиргааны эрх зүй, гүйцэтгэх алба, шүүхэд төлөөлж орсон байдлаар тодорхойлогддог.

*Нийгэм – хүн ам зүйн статус.* Угсаатны нийтлэгийн хүн амын тооны үзүүлэлт, түүндээ насны байдал, гэр бүл өрхийн бүтэц бүрэлдэхүүн, өвчлөлт ба хорогдолт, амьдрах дундаж нас зэргээр тодорхойлогддог. Эдгээрийн нэгтгэсэн үзүүлэлт нь угсаатны нийтлэгийн хөгжлийн түвшин, аж төрж буй байдлыг харуулаад зогсохгүй мөн нийгмийн хөгжлийн хурдац ба уналтыг баталгаажуулж байдаг. Тухайлбал, хүн амын дундаж наслалт нь нийгмийн хөгжлийн чухал үзүүлэлт болдог.

*Экологи статус.* Угсаатны нийтлэгийн эзэмшиж буй нутаг дэвсгэрийн хэмжээ, газрын гадаргуу (тал, уулархаг нутаг), цаг уур (халуун дулаан, хүйтэн, сэрүүн), хөрсний байдал (үр шимт, үр

шим муутай), ургамлын төрөл (ой модот, тал, говь, тайга гэх мэт), амьтны аймаг, оршин суугаа байдал (тодорхой нутгийн хүрээнд нягтралтай, эсвэл энд тэнд тархсан сийрэг, цөөн хүн ам) зэрэгтэй холбоотой. Энэ статусын нэг чухал үзүүлэлт нь тухайн нутаг дэвсгэрт хэр удаан суурьшсан явдал юм. Тухайбал, Еврей, Татарууд Беларусийн нутаг оронд 600 гаруй жил амьдарсан нь байгал, нийгмийн орчинд идээшиж, дасан зохицсоныг тодорхойлдог.

*Эрх зүйн статус* нь эдийн засаг, нийгэм, соёл, улс төрийн амьдралын явцад угсаатнууд эрх тэгш, эсвэл эрх тэгш бус оршин байгаагаар нь тодорхойлдог. Энэ нь угсаатны гишүүдийн эрмэлзэл нь тогтвортой, тогтвортой бус аж төрөхүйг нь илтгэнэ. Угсаатны зөрчил мөргөлдөөн нь үндэсний цөөнхийн эрх нь хохирсон, эс ойшоогдсон орчинд үүсдэг. Жишээлбэл, 1996 - 1997 онд Венгер, Словакийн зөрчил тэмцэл үүний тод нотолгоо болно. Словакид 50000 унгарууд оршин суудаг, тэд автономит төр улс байгуулж бие даан тогтнохыг эрмэлзсэн. Харин словакууд эрх зүйн хоёр зүйлийн баримтыг баталж хөдөлгөөнийг нь даржээ. Эхнийх нь Словаки дахь үндэсний цөөнх ямар нэгэн төр улсын институт байгуулахыг хориглосон, хоёрдох нь үндэсний цөөнхийн хэлийг хориглосон байв. Тэгснээр унгаруудын улс төрийн тэмцэл хийх, үндэснийхээ хэлийг хүртэл хэрэглэхийг хоригложээ. Тэгснээр үндэснийхээ цөөнхийн эрх ашгийг хохироож тэдний хооронд угсаатны нийтлэгүүдийн зөрчил мөргөлдөөнд аяндаа хүргэсэн.

*Нийгэм - сэтгэл зүйн статус.* Хүмүүнлэг ёсоор аж төрөх тодорхойлолтыг бүрдүүлэхэд үндсэн үүрэг гүйцэтгэдэг. Үндэсний шинж чанар (национальный характер), зан авир (темперамент), угсаатны нэрээр агуулагдах ижилсэлт ба ухамсрын онцлог, уламжлал, ёс заншил, ёс суртахуун, угсаатны дотоод гадаад эв нэгдэл, гомдол гутралт, түгшүүрт байдал, сэтгэл үл ханах, түүхэн ухамсар, түүхэн ой ухаан, таашаал ба амьдрах хэв маяг зэргээс бүрддэг.

Үүнээс үзэхэд угсаатны статус нь угсаатны нийтлэг, түүний гишүүдийн амьдран тогтнох орчинг бүрдүүлж буй тогтолцоот түмэн хүчин зүйлийн иж бүрдлээр нөхцөлддөг бөгөөд оршин байгаа газар орон, нийгэм - эдийн засгийн хөгжлийн түвшин, гадаад улс орон, ард түмнүүдтэй харилцаж байгаа байдал, үндэсний соёлын онцлог, ухамсар, түүхэн хөгжлийн нөхцөл бололцоо зэргээс шууд шалтгаалдаг байна.

#### **Ашигласан ном зохиол.**

1. “*Этнос и политика*”. Хрестоматия. Автор – составитель д-р ист. наук А.А. Прусаускас. – М.,2000.
2. Riggs, Fred F. Ethnicity. 1985. P.11-23.
3. Despres, Louis. Ethnicity and Resource Competition in Plural Societies. The Hague, Paris: Mouton, 1975. P.195-199.
4. Бабосов Е.М. Прикладная социология. – Минск., 2000.